

**ТОГТООЛЫН ХАВСРАЛТАД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

Төрийн албаны тухай хуулийн 10.4, 20.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын 2021 оны 03 дугаар тогтоолын 1 дэх заалтын 4-т заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

"Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэлийг шинэчлэн тогтоох тухай" Засгийн газрын 2019 оны 7 дугаар сарын 3-ны өдрийн 276 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "Шинжлэх ухааны салбарын төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл"-ийн "Удирдах" албан тушаалын "ТҮШУ-5" зэрэглэлд "3. Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн захирал, дэд захирал" гэж, "ТҮШУ-4" зэрэглэлд "4. Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн нэгжийн дарга" гэж, "Гүйцэтгэх" албан тушаалын "ТҮШУ-3" зэрэглэлд "3. Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн судлаач" гэж, "ТҮШУ-2" зэрэглэлд "4. Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн ажилтан" гэж, "Туслах" албан тушаалын "ТҮШУ-1" зэрэглэлд "2. Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн туслах ажилтан" гэж тус тус нэмсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Л.ОЮУН-ЭРДЭНЭ

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД А.АРИУНЗАЯА